Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
гуравдугаар хавсралт

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”[1]

| **НЭГ. Товч танилцуулга[2]** |
|---|
| Архивын ерөнхий газар нь батлагдсан 107 орон тоотой. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.1, 2.2, 2.4 дэх заалтуудын хүрээнд нийт албан хаагчдын санал хураалтаар олонхийн дэмжлэг авсан 7 албан хаагчийг Архивын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/42 дугаар тушаалаар бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.<br>Ёс зүйн дэд хорооны 1 гишүүн Төрийн албаны тухай хуулийн дагуу албан тушаалаас чөлөөлөгдсөн учир Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол улсын Ёс зүйн хорооны 2024 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын дагуу сул орон тоог нийт албан хаагчдын санал хураалтаар нөхсөн бөгөөд 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар 1 албан хаагчийг нөхөн томилсон.<br>Архивын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 арга хэмжээг хэрэгжүүлнэ. Тус арга хэмжээнүүд нь нийт албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилготой төлөвлөсөн. |
| **ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар** |
| 2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]: |
| 1. Архивын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооноос байгууллагын ажилтан, албан хаагчдын ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүүг урьж “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ, ойлголт, хандлага, эрх зүйн зохицуулалт” сэдвээр 107 албан хаагч, цахимжуулалт хариуцсан 28 ажилтан нийт 135 ажилтан, албан хаагчдад 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр сургалт зохион байгуулсан.<br><br>2. Ёс зүйн дэд хороо болон Захиргааны удирдлагын газрын санаачилгаар 2024-2025 онд шинээр томилогдсон болон Төрийн захиргааны нийт 26 албан хаагчдад 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр АТГ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, авлига албан тушаалтны хохирогч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр сургалт орсон. |

---

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

1. Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд томилох эрх бүхий албан тушаалтан буюу төсвийн шууд захирагч бүх талаас дэмжиж байгууллагын батлагдсан төсвөөс зарим үйл ажиллагааны төсвийг гаргасан.

2. Байгууллагын нийт албан хаагчдын сар бүрийн хуралд Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг тусгайлан танилцуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхийг бүх албан хаагчдад сануулан ажилласан.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

1. Ёс зүйн дэд хорооны дарга "Архивын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталсан.

2. Нийтийн мэдээллийн ил тод хангах хуулийн дагуу "Ёс зүйн хорооны мэдээллийн самбар" болон "Захидал хүлээн авах хайрцаг" 06 сард хийж байгууллагын 2 давхарт байршуулан ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой мэдээллийг олон нийтэд болон албан хаагчдад хүргэж байна.

3. Архивын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр "Байгууллагын ёс зүйн байдалд дүн шинжилгээ хийх судалгаа"-г байгууллагын нийт ажилтан албан хаагчдаас авсан. Энэхүү судалгаанд нийт **78** албан хаагч оролцсон байна. Уг судалгаа нь нийт **3** хэсгээс бүрдсэн **24** асуулттай.

<u>Судалгааг нэгтгэж дүгнэхэд:</u>

- Судалгааны үр дүнгээ хамт олны санал хүсэлтэд тулгуурласан арга хэмжээг үе шаттай зохион байгуулах, тогтмол давтамжтай.
- Судалгаа санал хүсэлт нь таны ажиллах таатай орчны бүрдүүлж чадна гэсэн итгэлийг өгөх
- Удирдлагууд хандлага, ёс зүй, харилцаандаа анхаарах, манлайлах
- Аливаа ажил арга хэмжээ зохион байгуулахдаа нэгж, газар бүрээс хүн бүрдүүлэх замаар ажилтан, албан хаагчдыг ойртуулах, танилцуулах, нөхөрлүүлэх боломжийг бүрдүүлэх
- Ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг үнэлэх, сургалт нөлөөллийн ажлын явцад хандлага ёс зүйтэй ажилтан, албан хаагчдаа урамшуулах гэсэн саналууд гарсан.

<u>Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:</u>

1. Ёс зүйн дэд хорооноос Ёс зүйн хорооны мэдээллийн самбар болон Захидал хүлээн авах хайрцгийн байршуулан ажиллуулж байна.
2. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор шат дараалсан сургалтуудыг зохион байгуулсан.
3. Байгууллагын албан хаагчдын дотоод группт холбогдох хууль тогтоомжийн талаар мэдээллийг тогмол оруулж байна. 2025 онд нийт 8 мэдээлэл оруулсан байна.

| Гарсан үр дүн, ололт амжилт: | Бэрхшээл: |
|---|---|
| 1. Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой санал, гомдол, талархал хүлээн авах "Захидал хүлээн авах хайрцаг"-ийг ажиллуулж эхэлсэн. | 1. Ёс зүйн дэд хорооны гишүүдэд гомдол мэдээлэл шалгасан гэдэг шалтгаанаар сөрөг хандлагыг илтэд гаргадаг.<br>2. Гомдол, мэдээлэл хянан шалгах үйл ажиллагааг тухай бүр нь тайлбарлаж өгсөн ч байгууллагад сөрөг мэдээлэл тархсан байдаг. |

| Санал: |
| --- |
| Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг сайн сурталчилах шаардлагатай байна. Мөн Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны зардлыг байгууллагын төсвөөс гаргах, Хуульд заасан урамшууллыг гишүүдэд олгох. |

**Шалгах хэсэг:**

- ☐ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.НЯМГЭРЭЛ

Ёс зүйн дэд хорооны дарга

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Б.ТУУЛ

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, ШАГНАЛ УРАМШУУЛАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Э.МӨНХ-ОРГИЛ

2026 оны 01 дүгээр сарын 02

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (3)

| № | Ангилал | Нэр | Агуулга | Хугацаа |
|---|---|---|---|---|
| 1. | Бусад | Байгууллагын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн болон дүрмийг шинэчлэх | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоол | 1-р улирал |
| 2. | Ёс зүйн асуудлаар санал асуулга зохион байгуулах | Байгууллагын Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөг боловсруулж, батлах | Албан хаагчдын хэрэгцээнд тулгуурлан боловсруулна | 1-р улирал |
| 3. | Ёс зүйн байдлыг тогтоох судалгаа хийх | Байгууллагын ёс зүйн байдалд тандан судалгаа, дүн шинжилгээ хийх | Судалгаанд үндэслэн арга хэмжээ зохион байгуулах | 2-р улирал |

## СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (4)

| № | Ангилал | Төрөл | Нэр | Агуулга | Хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1. | Нийт албан хаагчдын сургалт | Ажлын байрны эрүүл мэнд | Ажлын байрны дарамт, хүчирхийллээс ангид байх эрх | Ажлын байрны дарамт, хүчирхийлэл гэж юу вэ, түүнээс урьдчилан сэргийлэх | 2-р улирал |
| 2. | Нийт албан хаагчдын сургалт | Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх | Албан хаагчдад хуулийн мэдлэг олгох, ёс зүйн зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх | 2-р улирал |
| 3. | Бусад | Ёс зүйн зөрчил бий эсэхийг тандах | Ёс зүйн судалгаа, түүний үр дүнгийн танилцуулга | Албан хаагчдаас авсан ёс зүйн судалгааны үр дүнгийн танилцуулга | 2-р улирал |
| 4. | Нийт албан хаагчдын сургалт | Сэтгэл хөдлөлийн оюун ухаан (EQ) | Харилцаа, хандлага | Албан хаагчдын хандлага, харилцаанаас үүдэлтэй ёс зүйн зөрчлөөс сэргийлэх | 3-р улирал |

--oOo—

Ёс зүн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын
нэгдүгээр хавсралт

# АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ
# “ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

2026 оны 01 дүгээр сарын 02 Улаанбаатар хот

| № | Үзүүлэлт | Шалгуур үзүүлэлт | | Авбал зохих оноо | Оноо | Хувийн жин |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | | 4 | 5 | 6 |
| 1 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт | Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлтэй нийцүүлэн баталсан эсэх | | 1 | 1 | 10 |
| 2 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх | | 1 | 1 | 10 |
| 3 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сургийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал | Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батландсан агуулгын хүрээнд зохион байгуулсэн эсэх | 0.5 | 0.5 | 5 |
| | | | Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал | 0.5 | 0.5 | 5 |
| | | | Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал | 0.5 | 0.5 | 5 |
| | | | Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал | 0.5 | 0.5 | 5 |
| **Хэсгийн оноо** | | | | **4** | 4 | 40 |
| 4 | Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал | Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх | | 1 | 1 | 10 |
| 5 | | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал | | 1 | 1 | 10 |
| 6 | | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал | | 1 | 0 | 0 |
| **Хэсгийн оноо** | | | | **3** | 2 | 20 |
| 7 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа | Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал | | 1 | 1 | 10 |
| 8 | | Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал | | 1 | 1 | 10 |
| 9 | | Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж тайлагнасан байдал | | 1 | 1 | 10 |
| **Хэсгийн оноо** | | | | **3** | 3 | 30 |
| **Үнэлгээний нийт оноо, хувь** | | | | **10** | 10 | 90 |

БАЙГУУЛЛАГЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО